

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234715

МОНГОЛ, ХЯТАД ХЭЛНИЙ ҮЙЛДЭХ/ҮЙЛДҮҮЛЭХ  
УТГЫН АЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛ

Б.Одгэрэл

Түлхүүр үг: утга зүй, үйлийн ай, өгүүлбэр зүй, хэв шинж, BEI бүхий өгүүлбэр

Удиртгал

Хэл шинжлэлийн сав ухаанд орчин үеийн ололт амжилтыг багтаасан бүтэц хэл шинжлэл, нейро-, цахим-, түгээмэл хэлзүй, хэрэглээний хэл шинжлэлийн олон салаа салбар цаг үеийн шаардлагын дагуу хөгжсөөр байна. Энэ хүрээнд олон хэлний хэв шинжийн судлалд багтсан төрөл бус хэлний судалгаа ч өргөжин гүнзгийрсээр байна.


Хэлийг аливаа хүн амьдрал ахуйдаа хэрэглэхдээ харилцах үйлийн маш нарийн цогц болсон хэлний олон төрлийн хэрэглэхүүнийг наад зах нь өгүүлбэр, цаашлаад хэд хэдэн өгүүлбэрийг утга хийгээд хэлбэрээр нь авцалдуулан нэгтгэсэн өгүүлбэр, өгүүлэмж, тэдгээрийн бүтцэд нэгтгэн төлөвшүүлж санаа бодлоо илэрхийлдэг гэдэгтэй өнөөдөр хэн ч маргахгүй болсон байна. Өөрөөр хэлбэл, *өгүүлбэр нь хэлний хэрэглээний хамгийн анхдагч нэгж мөн*. Өгүүлбэрзүйг “Хэлний үгс нийлж хэлц, өгүүлбэр, өгүүлэмж зэрэг илүү том нэгжийг хэрхэн бүтээхийг судалдаг хэл шинжлэлийн салбар” (Равдан. 2014: 28-29) гэж тодорхойлдог.

Магк С.Вакер “Өгүүлбэрзүй нь тодорхой ба тодорхой бусын хоорондын харилцаатай нягт хамааралтай. Ихэнх хэл тодорхой тооны үндсэн үгтэй, харин тэдгээр үгс хамтран тодорхойгүй тооны өгүүлбэр бүтээж чадна. Тиймээс хүн, тухайлбал англи хэлний их болон бага гарын толь бичгийг худалдан авдаг хэдий ч англи хэлний бүх өгүүлбэрийг жагсаасан лавлахыг худалдан авна гэж байхгүй. Учир нь орчин цагийн англи хэлний өгүүлбэрийг бүтээж, ойлгоход уян хатан хэрэглэгдэх дүрмүүд болон загварууд байдаг учраас тэр” гэжээ. Үүнийг Чомскийн түгээмэл хэлзүйн онолоор тайлбарлах хэрэгтэй болно.

Монгол хэл шинжлэлд Э. Равдан “Утгаас хэлбэрт хандсан судлалд өгүүлбэр, түүний төрөл зүйл, бүтэц болон түүнтэй холбоотой бусад олон асуудлыг ч өөр өнцгөөс авч үзэх бодит шаардлага урган гардаг. Өөрөөр хэлбэл, өгүүлбэрийг чухамхүү хэрэглээний тодорхой хүрээнд тухайн бодгалийн санаа бодлоо илэрхийлэх зорилго, өгүүлэх орчин нөхцөл, харилцагч хүмүүсийн нас, хүйсийн ялгаа, сэтгэл санааны байдал, шууд болон зайнаас харилцах эсвэл аман болон

бичгээр илэрхийлэх хэлбэр зэргийг нэг талаас, нөгөө талаас хөг аялга, өргөлт зэрэг хэлний хэрэглэхүүн, нүүрийн хөдөлгөөн, дохио **зангаа зэрэг хэл яриа дагалдах** хэрэглэхүүн зэргээс үүдэн авч үзэх ( Равдан. 2013:123-124) болсныг дараах өгүүлбэрээр **жишээлэн** тайлбарлажээ.

Утгазүй-хэлзүйн үйлдэх/үйлдүүлэх айг олон хэлний түгээмэл цогц гэж авч үзэхийн үндэслэлийг бид АНУ-ын хэлний философич Н.Чомски (Chomsky, N. (1957), Syntactic Structures. The Hague: Mouton) нэг сэдэвт бүтээлдээ анх дэвшүүлсэн linguistic competence (хэлний чадавх)–linguistic performance (хэлний хэрэглээ) хосолмол ойлголт,  $S \rightarrow NP VP$  өгүүлбэрийн гүн бүтцийн хувьсах дүрэм, авиалбар зүй, өгүүлбэрзүй, утгазүйгээр хязгаарласан хэлний түвшний ойлголтоос үүдэн дэвшүүлж байна. Зохиогчийн санаагаар гүн бүтэц нь дэлхийн нийт хэлний түгээмэл ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хэрэглээний анхдагч нэгж-өгүүлбэр нь харьцангуй бие даасан нэр, үйлийн бүлгийн “нийлбэр” ажээ. Үйлдэх/үйлдүүлэх утга нь үйл үг, үйлийн утга илэрхийлсэн нэрээр илэрнэ. Доор бид Чомскийн өгүүлбэрийн гүн бүтцээс үүдсэн өнгөн бүтцийн жишээг татаж илэрхийллийг нь харууллаа.



“Эрдэмтэн энэ хариултыг тогтоожээ” өгүүлбэр нь уламжлалт монгол хэлний өгүүлбэрзүйн үүднээс тусах үйл үгээр *үйлдэх* утга илэрсэн байна. Үйлдүүлэх утга нь англи хэлний хувьд бол *inversion* өгүүлбэрийн гишүүдийн урвах байрлалаар илэрдэг бол тэр нь бусад хэлд давтагдах ёсгүй. Өөрөөр хэлбэл, утга илэрхийлэх хэлбэр нь тухайн хэлний хэлзүйн тогтолцоогоор тогтоогдоно. Үйлдэх утга нь хэл бүрд хэлбэрийн үүднээс сайтар судлагдсан энгийн өгүүлбэрийн бүтэц бол, үйлдүүлэх утга нь гол төлөв, үйл үг, үйлийн утга хадгалсан нэртэй холбоотой тул бид энэхүү судалгааны бүтээлд үйлдүүлэх утгын илэрхийллийг төрөл бус монгол, хятад хэлэнд авч үзсэн болно. Монгол хэлэнд үйлдүүлэх утга нь үйл үгийн олон нөхцөл дагавраар илрэхээс биш, өгүүлбэрийн гишүүдийн дарааллаар төдийлөн илэрдэггүй.инжилсэн болно.

### 1. Монгол, Хятад хэлний үйлдэх/үйлдүүлэхийн утгын ай илэрхийлсэн өгүүлбэрийн бүтцийн хэв шинжийг зэрэгцүүлэх нь

Утга зүйн талаас үйл үгийн хэвийг өгүүлбэр зүйн түвшинд авч үзнэ. Учир зүйн хувьд дэлхийн олон хэлэнд өгүүлбэр SVO, SOV, VSO, VOS, OSV, OVS бүтэцтэй.

Ерөнхий хэл шинжлэлд Ж.Гринбергийн онолын дагуу хэлний нийтлэг үзэгдэлд өгүүлбэр зүйн нийтлэгүүд багтсан байдаг. Тухайлбал: Үйлийн эзэн ба тусагдахуунтай хүүрнэх өгүүлбэрт ихэнхдээ үйлийн эзэн тусагдахууны өмнө

байна. VSO бүтэц гол хэв шинж нь болдог хэл угтвартай. SOV дараалалтай хэл залгавартай гэх мэт. Энэ мэт өгүүлбэр дэх үгийн ангилал хэлний хэв шинжийн ангиллын нэгд багтдаг.

Монгол, хятад хэлний хэв шинж энэхүү ангиллын хоёр өөр төрөлд багтана. Тухайлбал: Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц SOV дараалалтай бол хятад хэл SVO бүтэцтэй байна. Тус хоёр хэлний энэхүү онцлог үйл үгийн хэвтэй өгүүлбэрт хэрхэн илэрч болохыг жишээ өгүүлбэр дээр авч үзье.

П.Бямбасан “Монгол хэлний үйл үгийн үйлдүүлэх хэв бусад хэвээсээ илүү их хэрэгцээтэй байдаг.” гээд “монгол хэлэнд үйлдүүлэх хэвийн хоёр шат байж болно. Нэг үйл үгээс гэх мэтчилэн үйлдүүлэх хэвийн олон шат үүсэж болно гэсэн баталгаа алтай хэл шинжлэлийн бичиг зохиолуудад элбэг тохиолддог. Жирийн ярианы хэмжээнд цэрвүүхэн бодоход монгол хэлний нэг үйл үгээс хатаалгуулах, тогтоолгуулах гэх мэтээр үйлдүүлэх хэвийн дагаврыг гурав дөрвөөр нь угсруулан авсан тийм үйл үг монголын орчин цагийн бичгийн утга зохиолын хэлний төрөл бүрийн найруулгын зүйлээс олоход бэрхтэй. Аман яриа ба бичгийн утга зохиолын хэлний ийм нөхцөл байдлаас болоод одоо үед монгол хэлний үйл үгийн үйлдүүлэх хэвийн олон шатны асуудал мөн л таамаг төдий байна” ( Бямбасан. 2006: 149-150) гэж үйлдүүлэх хэвийн бүтэц, найруулгын үүднээс бичсэн ч түүнийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг сануулсан байна. Түүнчлэн эрдэмтэн Н.Нансалмаа “Хэл бол хүний бодол санаа, хүсэл зориг, мэдрэмжийг илэрхийлэх хэрэглүүрийн тогтолцоо юм” (Нансалмаа. 2014:8-9) гэсэнчлэн үйлдүүлэхийн утгын айн бүтцийн хэв шинжийг зэрэгцүүлэн үзэх арга зүйн зарчмыг баримтлан судалсан болно. Ингэхдээ 1990 онд хэвлэгдсэн «Монгол өгүүллэг» номоос монголын орчин үеийн уран зохиолын шилдэг бүтээлийг эх хэрэглэгдэхүүн болгосон болно.

### 1) Монгол хэл

(1) *Сэрээнэн гуай хүнд юм зээлдүүлж тус хүргэж үзээгүй.* ( Ванган Д.1991:48-49)

S O V

(2) *Цай хийлгэ хийлгэ.* ( Дорж. Д. 1991:163-164)

S V

(3) *Аавын дардаг морины явдал надад төдий л сайхан санагддаггүй.*

O S V

(Бааст. Б. 1991:15-16)

(4) *Тариа услахаар ирсэн хүмүүс ялаа шумуулд үхтлээ хазуулж* ( Бааст. Б. 1991:23-24)

O S V

(5) *Хууртагдчихлаа би түүнд*

V O S

Дээрх жишээнээс үзэхэд монгол хэлний үйл үгийн хэвтэй өгүүлбэр нь SOV (Жишээ: 1,5), OSV (Жишээ: 3,4), гэсэн хэв шинжтэй байх боломжтой юм. Өөрөөр хэлбэл ганц төрлийн хэв шинжид баригддаггүй байна. Түүнчлэн харилцан үйлдэх хэв бүхий өгүүлбэрийн үйл үг гол төлөв эс тусах үйл үг байдгаас шалтгаалж SV бүтэцтэй.

## 2) Хятад хэлэнд:

Хятад хэлний үйлдэх/үйлдүүлэх айн хэв шинж илэрхийлсэн “BEI” (被) бүхий өгүүлбэрийн үндсэн бүрэлдэхүүнд А, “BEI” (被), В болон VP гэсэн өгүүлбэрийн гишүүд багтана. Гэвч VP-гийн олон төрлөөс хамаарч ийм төрлийн өгүүлбэрийн үндсэн бүтэц ч мөн адил бус байна. Эдгээрийг А “BEI” (被) BV хэлбэр, “А “BEI” (被) BV 了 / “ZHE” (着) / “GUO” (过)” хэлбэр, “А “BEI” (被) BVR” хэлбэр, “А “BEI” (被) BVO” хэлбэр, “А “BEI” (被) BVP1 VP2” гэж тав ангилах боломжтой. Хэв шинжийн үүднээс “А 被 BV” гэсэн бүтэц харьцангуй түгээмэл юм.

- А “BEI” (被) BV  $\longrightarrow$  SOV

Жишээлбэл: 我被他恨死了。 Тэр намайг үхтлээ үзэн ядав.

Би түүгээр үхтлээ үзэн ядагдав.

- А “BEI” (被) BV “LE” (了), “ZHE” (着), “GUO” (过)  $\longrightarrow$  SOV

苹果被我吃了。 Би алим идсэн.

Алим надаар идэгдэв.

门被他笑着。 Тэр хаалга хаасан.

Түүгээр хаалга хаагдсан.

桌子上的东西没被人动过。 Ширээн дээрх зүйлийг хүн хөдөлгөөгүй.

Ширээн дээрх зүйл хүнээр хөдлүүлээгүй.

- А “BEI” (被) BVR  $\longrightarrow$  SOV

他被人赶出去了。 Тэр хүнд хөөгдөж гарсан.

Тэр хүнээр хөөгдөж гарсан.

- А “BEI” (被) BVO  $\longrightarrow$  SOV

他被授予“劳动模范”的称。 Тэрээр “хөдөлмөрийн үлгэр жишээ” гэх нэрээр нэрлэгдэх болсон.

他被授予“劳动模范”的称。

Тэрээр алдраар “хөдөлмөрийн үлгэр жишээ” нэрлэгдсэн.

- А “BEI” (被) BVP1 VP2  $\longrightarrow$  SOV

他经常被父母打骂。 Тэр байнга эцэг эхдээ загнуулж зодуулдаг.

Тэр байнга эцэг эхээрээ загнуулж зодуулдаг

Дээрх ангиллаас үзэхэд хятад хэлний үйлдэх/үйлдүүлэх айн хэв шинж бүхий “BEI” (被) –тэй өгүүлбэрийн бүтэц нь SOV гэсэн тогтсон хэв шинжтэй байна. Түүнчлэн ийм төрлийн өгүүлбэрийн үйл үг нь зөвхөн тусах үйл үг байдаг.

Монгол, Хятад хэлний үйлдэх/үйлдүүлэх айн хэв шинж бүхий өгүүлбэр нь үндсэн хэв шинжээсээ өөр байх боломжтой хэдий ч хятад хэлний хувьд тэрхүү шинж чанар нь тогтвортой бол монгол хэлнийх тогтворгүй байна. Үүнээс үзвэл монгол, хятад хэлний үйлийн айг илэрхийлсэн өгүүлбэр нь бүтцийн хэв шинжээрээ нийтлэг бус юм.

## **2. Монгол, Хятад хэлний үйлийн утгын айн хэв шинжийг илэрхийлсэн өгүүлбэрийн онцлог**

Эрдэмтэн Э.Равдан «Орчин цагийн хэл шинжлэл» номд өгүүлбэрийн утгыг 1. Бүтцийн салаа утга, 2. Утгын хуваарилалт, 3. төлөөний нэрийн үүрэг гэж гурав ангилан тодорхойлсон. Ингэхдээ өгүүлбэрийн гүн бүтэц ба бүтцийн утгыг “идэвхгүй хэв дэх өгүүлбэрийн бүтцийн задаргаа нь уг өгүүлбэр хоёр гүн, нэг өнгөн бүтэцтэй гэж үзэхээр байна. Бүтцийн бүрэлдэхүүний утга нь гүн бүтцийн үйлийн бүлгийн бүрэлдэхүүнд багтсан NP нь нэг талаас үйлийн тусгал буюу сэдэв, нөгөөтээгүүр нэр үгийн хэл зүйн бүтээврийн N<sub>3</sub>-ийн үрээр үйлийн эзний үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэж байгаагаас үүдэн гарч байна. Гүн бүтцийн үйлийн бүтцийн бүрэлдэхүүнд байгаа NP-ийг нэрийн бүлгийн байршилд шилжүүлэн өнгөн бүтцийн хувиргалд оруулахад уг өгүүлбэр хэлбэр хийгээд утгын хувьд зөв зохистой болж гэж үзвэл зохино” (Равдан. 2000:200-201) гэж үйл үгийн хэвтэй өгүүлбэрийн жишээн дээр тайлбарласан байдаг.

Монгол, Хятад хэлний үйл үгийн хэв утгын айн хэв шинжийг дээрх тайлбарыг үндэс болгон харьцуулж үзье.

### **1) Монгол хэлний үйлийн айн хэв шинж:**

(1) *Залуу вансэмбэрүүний толгойг зөөлөн илбэхэд.* (Бизъяа.)

Дээрх өгүүлбэрийн 1) жишээ нь оногдохуй нь “вансэмбэрүү” бол онохуй нь “залуу” гэсэн үг байна. Тус өгүүлбэрийн гүн бүтэц нь “Вансэмбэрүү залуугаар илбүүлсэн” гэсэн утгыг агуулж байна.

(2) *Пийсүү Тунсаг өөрийгөө хүндлүүлэх дуртай хүн байсан.* (Бадарч.)

(3) *Өдөр ах намайг дагуулан усанд явлаа.* (Бааст.)

(4) “Зоригт” эр, арслангийн хоншоорыг хуга цохиж “номхотгосон” юм байжээ. (Бадарч.)

Дээрх өгүүлбэрийн (3), (4) –р өгүүлбэр нь бүгд үйлдүүлэх утгыг илэрхийлсэн байна.

(5) *тод үгс тунгалаг агаарт цацагдан...* (Ванчаарай.)

Жишээ (5) өгүүлбэрт оногдохуй нь “тод үгс” бөгөөд бусдын нөлөөгөөр “агаарт цацагдсан” тул үйлдүүлэх гэсэн гүн бүтцийг агуулж байна.

(6) *Ч.Ойдов БНМАУ-ын төрийн шагналыг 1947 онд хүртжээ.*

Энэ жишээнд онохуй нь “Ч.Ойдов” хэдий ч “бусдаар шагнуулжээ” гэсэн утга бүхий гүн бүтэцтэй байна.

(7) *Адгуус юм тулд л хүн түүнийг аргагүй эрхэндээ оруулж арван хэд хоног ноцолдон байж арай гэж тэргэнд сургажээ.* (Занраабайдий.)

Дээрх өгүүлбэрийн онохуй нь “Адгуус” бөгөөд бусдын нөлөөгөөр тэргэнд орж сурсан гэсэн гүн бүтцийг агуулж байна.

Дээрх жишээнээс үзвэл монгол хэлний үйлийн айн хэв шинжийг илэрхийлсэн өгүүлбэрийн утгын айд өөрөө үйлдэх хэв, үйлдэгдэх хэв зэрэг нь гүн бүтцийн үүднээс үйлдүүлэх утгыг агуулж байна. Тиймээс хэл шинжээч, эрдэмтэн Э.Равдан суурь үйлдүүлэх бүтэц гэж “бусад бүтцээс (1) Үйлдэгчийн бүлэггүй, (2) Гол үйл үг нь тусах хэлбэргүй, (3) Гол үйл үг нь үйлдэгч хийгээд үйлдүүлэгч оногдохуйг агуулсан үйлдүүлэх хэлбэрээр үйлийг илэрхийлсэн байдгаараа эл бүтэц нь дэлхийн олон хэлний хамгийн өргөн тархсан хэлбэр тул түүнийг бид “суурь” хэмээн нэрлэв” (Э.Равдан, Олон хэлний хэв шинжийн судлал, 2020, хууд. 228) гэж олон хэлний хэв шинжийн судлалын үүднээс үйлдүүлэх хэвийн нийтлэг байдлыг тодорхойлсон байдаг. Түүнчлэн П.Бямбасан “Эрдэмтэд үйлдүүлэх хэвийн дагавартай үйл үгээс шалтгаалж өгүүлбэрийн дотор байж байгаа үгийг учир зүйн үүднээс үйлийн жинхэнэ гүйцэтгэгч эзэн, үйлийг сэдэгч эзэн гэж ялган ярилцаж байна. Үйлийг сэдэх эзэн нь үйлдүүлэх хэвийн дагавраар хэлбэржсэн үйл өгүүлэхүүний хэлзүйн өгүүлэгдэхүүн болж нэрлэхийн тийн ялгалаар (хааяа гарахын тийн ялгалаар) байнга хэлбэрждэг.” (Бямбасан. 2006:206-207) гэж үйлдүүлэхийн утгын айн онцлогийг тайлбарласан байдаг.

## **2) Хятад хэлний үйлийн айн хэв шинж:**

Хятад хэлний хувьд үйл үгийн хэвийн утгын айн хэв шинжид оногдохуйн үүрэг чухал үүрэгтэй. Мөн хятад хэлний үйлдэх/үйлдүүлэх айн хэв шинжийг илэрхийлэх “BEI” (被) бүхий өгүүлбэрийн монгол хэлэнд үйлдэх, үйлдэгдэх, үйлдүүлэх хэвээр илрэхээс бус харилцан болон хамтран үйлдэх хэвээр илэрдэггүй. Нарийвчлан үзвэл монгол, хятад хэлэнд үйлдүүлэх хэв түгээмэл байдлаар илэрнэ. Энэ нь тус хоёр хэлний утгын айн хэв шинж үйлдүүлэх хэв гэдгийг батлах нэг үндэслэл болж байна. Жишээ өгүүлбэрээр авч үзвэл:

1) 宝玉被一个林黛玉缠绵住了。 Хишгээр Бао Юй нэгэн Линь Дай юйд төөрөгдөн ороогдов.

2) 盘子被拌碎了。 Тавгийг хутгаад хагалчхав.

3) 我被你吓死了。 Чи намайг үхтэл цочоолоо.

4) 让人想起刚撒尿划完地盘就被主人轰出去的小狗。

хивсэн дээр савируулаад эзэндээ хөөгдсөн нохой шиг уур цухалтай харагдана.

Дээрх жишээ өгүүлбэрүүдэд үйлдүүлэх хэв шинжийн утгыг илэрхийлж байна.

## Дүгнэлт

Монгол, Хятад хэлний үйл үгийн хэвийн айн утгын хэв шинжийг харьцуулахад монгол хэлний үйлдэх/үйлдүүлэх хэв нь хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн утгыг бүрэн илэрхийлэх боломжтой юм. Үүнд үндэслэн дүгнэвэл монгол хэлний үйлдүүлэх хэв нь олон хэлний түгээмэл утга зүйн ай гэж үзэж байна.

## Ном зүй

- Амар. Г, Алтанхуяг. Д ред. Монгол өгүүллэг. Уб., 1991  
Бямбасан П. 2006. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Уб.,149 х.  
Равдан Э. 2013. Хэрэглээний хэл шинжлэл. Уб., Удам соёл ХХК. 123 х.  
Равдан Э. 2020. Олон хэлний хэв шинжийн судлал. Уб., Удам соёл. ХХК. 228 х.  
Равдан Э. 2020. Орчин цагийн хэл шинжлэл II.Уб., Удам соёл ХХК.79 х.

## Abstract

To enhance clarity regarding the structural, functional, and semantic aspects of Mongolian and Chinese verbs, as well as Mongolian action types and their manifestation in Chinese, this paper conducts a comparative analysis of verb patterns. By examining how Mongolian and Chinese action patterns intersect and diverge, and through the analysis of original literature examples, commonalities in action patterns across both languages are delineated. Additionally, this study elucidates the inherent meanings associated with actions in Mongolian and Chinese contexts.